



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 04/33

Баян-Өндөр сум

**Өсвөрийн улсын аварга шалгаруулах
тэмцээнд хөрөнгө гаргах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д.Дашбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тэмцээнд зарцуулагдах 11,082,400 (арван нэгэн сая наян хоёр мянга дөрвөн зуу) төгрөгийг зохих журмын дагуу өсвөрийн шигшээ багийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

המסמך מתאריך 15.12.2019



המסמך מס' 15.12.2019

נושא - המסמך

מסמך 15.12.2019

מסמך 15.12.2019

המסמך מס' 15.12.2019

המסמך מס' 15.12.2019

המסמך מס' 15.12.2019

המסמך מס' 15.12.2019

המסמך מס' 15.12.2019

מסמך 15.12.2019

612502026

ӨСВӨРИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 2-р дугаар сарын 16-ны өдрийн
04/33 дугаар тушаалын хавсралт

№	Спортын төрлийн нэр	Унааны зардал			Байрны зардал			Хоолны зардал			Бүгд (төгрөгөөр)
		Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Дүн	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Дүн	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Дүн	
1	Байт харваа	-	-	-	19 хүн х3 хоног	25,000	1,425,000				1,425,000
2	Үндэсний бөх Үндэсний бөх Эрдэнэт-Өвөрхангай-Эрдэнэт 450 кмх2 талдаа=900 км 100 км=20л 900 км=180л 1 машин Фургон	180л	2,550	459,000	-	-	-	15 хүн х 3 өдөр	20,000	900,000	1,359,000
3	Даам Эрдэнэт-Улаанбаатар Эрдэнэт 400кмх2 талдаа=800 км 100 км=10л 800 км=80л 3 машин 240л	240л	2,500	600,000	-	-	-	30 хүн х 2 өдөр	20,000	1,200,000	1,800,000
4	Ширээний теннис Вагон 42 хүүхэд 2 талдаа	42	17,600	1,478,400				42 хүн 1 хоног	20,000	840,000	2,318,400
5	Жудо бөх	-	-	-	27 хүн х2 хоног	25,000	1,350,000	27 хүн х 3 өдөр	20,000	1,620,000	2,970,000
6	Хөнгөн атлетик				11хүн х2 хоног	25,000	550,000	11хүн х3 хоног	20,000	660,000	1,210,000
Төсвийн нийт дүн											11,082,400

-----ООо-----